



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2025/058/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 132

танай _____ ны № _____ т

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН
ДАРГА Г.АЛДАРМӨНХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

"Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолын дагуу "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2023 оны XIX/08 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 36.3 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол

632502195

асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 1 хөтөлбөр 3 зориулалт арга хэмжээний хүрээнд 420.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 367.2 сая төгрөгийг зарцуулж 55.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГТИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,380.7	14,091.7
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	53,024.9	131,698.1
Нийт хөрөнгийн дүн	59,405.6	145,789.8
Нийт өр төлбөрийн дүн	0.0	12.1
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	59,405.6	145,777.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	59,405.6	145,789.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	523,528.4	974,062.7
Үйл ажиллагааны зардлын дүн	517,778.0	887,690.6
Үйл ажиллагааны үр дүн	5,750.4	86,372.0
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	5,750.4	86,372.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,655.2	59,405.6
Тайлант оны үр дүн	5,750.4	86,372.0
Эцсийн үлдэгдэл	59,405.6	145,777.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	513,639.3	894,877.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	505,808.3	869,877.9
Үйл ажиллагааны ЦМГ	7,831.0	25,000.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(7,831.0)	(25,000.0)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		364,058.5
Урсгал зардал		364,058.5
Хөрөнгийн зардал		-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		364,058.5
Улсын төсвөөс санхүүжих		364,058.5
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 209,904.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 209,904.1 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- Албан хаагчдын ажилласан жилийн нэмэгдлийг 306.5 мянган төгрөгөөр илүү тооцсон нь УСНББОУС-1, 2, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдэл,
- Санхүүгийн программын 2025 оны сунгалтын төлбөр 440.0 мянган төгрөгийг тайлан бүртгэлд урьдчилж гарсан зардлаар тусгаагүй, УСНББОУС 1, 12, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Бараа болон үйлчилгээг авахаас өмнө 209,145.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон ч авлагын дансаар бус өглөгийн дансаар дамжуулах журнал бичилт хийсэн УСНББОУС 1, 12, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдэл,
- Албан хаагчийн ажилласан жилийн нэмэгдлийг 12.1 мянган төгрөгөөр дутуу тооцож олгосон нь УСНББОУС 1, 12, тасалбар болголт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 3,900.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 3,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 900.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,900.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,952.9 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

3.2 Албан шаардлага

1. Бараа үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

3.3 Зөвлөмж

1. Түүвэрт хамрагдсан томилолтын зардлыг Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалын дагуу төсвийг баталгаажуулаагүй нь Сангийн сайдын 2024 оны А/52 тоот тушаалын 2 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, журмын заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах ю

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СУАЖЗГ	5	209,904.1	3	758.6	2	209,145.5	5	209,904.1	0	0	0	0
Дүн	5	209,904.1	3	758.6	2	209,145.5	5	209,904.1	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
СУАЖЗГ	2	3,900.0	0	0	1	3,000.0	1	900.0	0	0	0	0
Дүн	2	3,900.0	0	0	1	3,000.0	1	900.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
СУАЖЗГ	0	-	0	-	0	-	0	-
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Нийт дүн	0	-	0	-	0	-	0	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			